

**САНГИЙН САЙД, МОНГОЛЫН МЭРГЭШСЭН НЯГТЛАН БОДОГЧДЫН
ИНСТИТУТИЙН ЕРӨНХИЙЛӨГЧТЭЙ 2023 ОНД БАЙГУУЛСАН "ТӨРИЙН
БАЙГУУЛЛАГЫН ЗАРИМ ЧИГ, ҮҮРГИЙГ ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГААР
ГҮЙЦЭТГҮҮЛЭХ ГЭРЭЭ"-Г ДҮГНЭСЭН АКТ**

2023 оны 12 дугаар сарын 28-ны өдөр

1. ЕРӨНХИЙ ЗААЛТ

Гэрээний нэр	Төрийн байгууллагын зарим чиг, үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх гэрээ
Гэрээний дугаар	44
Захиалагч байгууллага	Монгол Улсын Сангийн яам
Захиалагч байгууллагын төлөөлөх эрх бүхий нэгж	Сангийн Яамны Нягтлан бодох бүртгэлийн бодлогын газар
Гүйцэтгэгч байгууллага	Монголын Мэргэшсэн Нягтлан Бодогчдын Институт
Гэрээ дүгнэсэн огноо	2023 оны 12 дугаар сарын 28-ны өдөр

2. ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТ

Гэрээний тусгай нөхцөл	Биелэлт	Хувь
2.1.1 Мэргэшсэн нягтлан бодогч бэлтгэх хөтөлбөр сургалтын агуулга, сургалт шалгалтын тогтолцоог олон улсын жишигт нийцүүлэх, шалгалтыг цахим хэлбэрээр зохион байгуулах;	<p>1. Мэргэшсэн нягтлан бодогч бэлтгэх шинэчилсэн хөтөлбөрийг хэрэгжүүлэх:</p> <ul style="list-style-type: none">- Мэргэшсэн нягтлан бодогч бэлтгэх шинэчилсэн хөтөлбөр болон сурах бичгийн нэмэлт, өөрчлөлтүүдийн танилцуулга видеог хичээл тус бүрээр бэлтгэж, динамик системд байршуулсан.- Шинэчилсэн хөтөлбөр 2022-ын дагуу гэрчилгээний түвшний 5 хичээл, мэргэжлийн түвшний 1 хичээлийн сурах бичгийг шинээр боловсруулах, мэргэжлийн түвшний 4 хичээлийн сурах бичиг, гарын авлагад дахин хяналт хийх гэрээ тус тус байгуулагдсан. Гэрээний дагуу гүйцэтгэх ажлын даалгавруудыг тухай бүр хүлээн авч, сурах бичиг, гарын авлагууд жилийн турш гэрээнд заасан хугацаанд хийгдэж байна.- Санхүүгийн тайлагнал хичээлийн 6 сэдэв, гүйцэтгэлийн удирдлага хичээлийн 5 сэдэв, санхүүгийн менежмент хичээлийн 4 сэдвээр шинэчилсэн видео хичээл бэлтгэж, динамик системд байршуулсан.- Гэрчилгээний ба мэргэжлийн түвшний бүх хичээлүүдийн сурах бичиг, гарын авлагуудад дахин хяналт хийж, тус бүр 300-500 ширхэг хэвлүүлэн сургалтад ашигласан.- Ахисан түвшний "Корпорацын ба бизнесийн тайлагнал", "Засаглал, эрсдэл, хяналт" хичээлүүдийн сурах бичгийг хөтөлбөрийн шинэчлэлийн дагуу дахин редакторлаж, шинээр хэвлүүлсэн. Мөн эдгээр хичээлүүдийн тестийн санд нэмэлт баяжуулалт хийгдсэн.	95%

	<p>- "Ахисан түвшний гүйцэтгэлийн удирдлага" багц хичээл (лекцийн материал, видео хичээл, тест), сурх бичгийг шинээр боловсруулж, хэвлүүлэх гэрээ хийгдсэн. Сурх бичгийн эх бэлтгэлийг 12 сард бүрэн дууссан ба 2024 оны 1 дүгээр улиралд хэвлүүлнэ.</p>	
	<p>2. Мэргэшсэн нягтлан бодогчийн шалгалтын агуулга, бүтцийг Олон улсын ижил төстэй мэргэжлийн байгууллагуудынхтай харьцуулан судлах, шалгалтын платформын шинэ хувилбарыг олон нийтэд танилцуулах:</p> <ul style="list-style-type: none"> - АНУ, ACCA, Австрали, БНСҮ, БНХАУ, БНЭУ-н МНБ-ийн эрх олгох шалгалтын агуулга, бүтцийн судалгаа хийсэн. - Судалгааны үр дүнд үндэслэн шалгалтын платформын шинэчлэл хийхээр программын хөгжүүлэгчидтэй санал солилцож, Гөү Смарт ХХК-тай хамтран ажиллахаар гэрээ байгуулсан. - Шалгалтын платформын эхний хувилбар бэлэн болж, дотооддоо туршилт хийж байна. 2024 оны 2 дугаар сараас туршилтын хувилбарыг шалгалтын үйл ажиллагаанд нэвтрүүлнэ. 	94%
	<p>3. Мэргэшсэн нягтлан бодогчийн эрх олгох болон сунгах шалгалтыг цахим хэлбэрээр авах:</p> <ul style="list-style-type: none"> - Сангийн сайдын 2016 оны 2 дугаар сарын 29-ний өдрийн 82 дугаар тушаалаар батлагдсан Монгол Улсын мэргэшсэн нягтлан бодогчийн эрх олгох шалгалтын журмын дагуу мэргэшсэн нягтлан бодогчийн дөрвөн жилийн эрх олгох шалгалтыг 2023 оны 6, 12 дугаар саруудад нийт 4 удаа зохион байгууллаа. - Мэргэшсэн нягтлан бодогчийн дөрвөн жилийн эрх олгох 4 удаагийн шалгалтад нийт 3,648 хүн оролцсон бөгөөд тэнцлийн дундаж түвшин 17.92 хувьтай байсан. Шалгалтын үр дүнд нийт 137 хүн Мэргэшсэн нягтлан бодогчийн дөрвөн жилийн эрхтэй болсон. - Мөн мэргэшсэн нягтлан бодогчийн эрх авснаас хойших 2 дахь жилийн сургалтыг 2023 оны 5, 11 дүгээр саруудад 2 удаа зохион байгуулсан. Уг сургалтад 236 мэргэшсэн нягтлан бодогч хамрагдан шалгалтад оролцсон. Шалгалтын үр дүнд нийт 209 мэргэшсэн нягтлан бодогч 2 дахь жилийн сургалтаа амжилттай төгссөн байна. - Холбогдох журмын дагуу мэргэшсэн нягтлан бодогчийн хугацаагүй эрх олгох сургалтыг 2 удаа зохион байгуулж, сургалтад 341 мэргэшсэн нягтлан бодогч хамрагдсан. Шалгалтын үр дүнд нийт 332 хүн мэргэшсэн нягтлан бодогчийн хугацаагүй эрхтэй болсон. - Батлагдсан төлөвлөгөөний дагуу мэргэжлийн түвшний шалгалт бүрд 300 тест, нийт 1,200 тестийг шинээр боловсруулж, тестийн санг баяжуулсан. - Ахисан түвшний хичээлийн шалгалтын нийт 310 тест боловсруулж, тестийн сангийн баяжуулалт хийсэн. 	98%

	<p>4. Аудитын компаниудад хийх чанарын хяналтыг хэрэгжүүлэхэд оролцох:</p> <ul style="list-style-type: none"> - Сангийн сайдын 2023 оны 4 дүгээр сарын 11-ний өдрийн 79 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэгт Институтийн Аудит, ёс зүйн асуудал хариуцсан дэд захидал болон Аудит арга зүй хариуцсан менежер нар ажиллалаа. - Улмаар дэд ажлын хэсгийн хамт нийт 12 аудитын компанийд Чанарын хяналт хийж, холбогдох дүн, дүгнэлт, зөвлөмж боловсруулж, тайланг бэлтгэн хүргүүлсэн байна. 	100%
2.1.2 Аудитын үйл ажиллагааны стандарт, чанарын хяналтыг хэрэгжүүлэх, цахим мэдээллийн санг боловсруулж, хөгжүүлэх;	<p>5. Аудиторын сургалтын хөтөлбөрийн агуулгыг Шинэчлэгдсэн Аудитын Олон Улсын Стандарт 2020-д нийцүүлэн боловсруулах:</p> <ul style="list-style-type: none"> - Аудиторын сургалтын хөтөлбөр, агуулгыг ACCA-Advanced Audit and Assurance-2023 хөтөлбөрт нийцүүлэн шинэчлэн боловсруулсан. Үүнд, Аудитын Олон Улсын Стандарт 2020, Чанарын Удирдлагын Олон Улсын стандартуудын хичээлүүд болон мэргэжлийн ур чадварын хичээлүүдийг шинээр тусгаснаас гадна өмнө бэлтгэгдсэн аудитын сургалтын зарим хичээлийн агуулга, мэдээлэл болон видео хичээлийн бичлэгийг шинэчилсэн. Эдгээр ажлын үр дүнд аудитын сургалтын хөтөлбөр 60 хувиар шинэчлэгдсэн. - Дээрх шинэчлэлтийн хүрээнд нийтдээ 7 ерөнхий сэдвийн дагуу 1,640 цагийн хичээл шинээр бэлтгэгдсэн. Аудитын Олон улсын Стандартуудын шинэчлэлтэй холбогдуулан Чанарын удирдлагын олон улсын стандартын ЧУОУС-1, ЧУОУС-2 болон шинэчлэгдсэн АУОС-220 стандартуудыг танилцуулах Гарын авлага-1, Мөнгө угаалттай тэмцэх асуудлууд, Мэргэжлийн ёс зүй, Аудитын холбогдох үйлчилгээ ба Орчин үеийн аудитын төрөл сэдвүүдийг агуулсан Гарын авлага-2-ыг шинээр боловсруулж, аудиторын сургалтад оролцогчдод цахим хэлбэрээр хүргэж, судлуулж байна. - Мөн олон улсын сүлжээ аудитын фирмийн партнериүүдтэй хамтран цуврал видео хичээл бэлтгэж, орчуулан, аудиторын сургалтын хөтөлбөрт мэдлэг, ур чадварыг хөгжүүлэх нэмэлт судлах материал болгон тусгаж, суралцаагчдад хүргэх ажлыг эхлүүлээд байна. 	100%
2.1.3 Мэргэжлийн, мэргэшсэн нягтлан бодогч, аудиторын ёс зүйг сайжруулах, хяналт тавьж хариуцлага тооцох;	<p>6. Тусгай зөвшөөрлийн цахим систем /https://license.mof.gov.mn/-ийн Аудитын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн модуль сайжруулалтын үйл ажиллагааг жигдруулэх:</p> <ul style="list-style-type: none"> - Аудитын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүссэн нийт 20 хуулийн этгээдийн хүсэлт (эхний хагас жилд 13, сүүлийн хагас жилд 7)-ийг хүлээн авч, тусгай зөвшөөрөл олгуулах саналыг хэлэлцэж, шийдвэрлэх ажлын хэсгийн хурлыг 2023 оны 1 дүгээр сарын 18, 6 дугаар сарын 20 болон 12 дугаар сарын 12-ны өдөр нийт 3 удаа зохион байгууллаа. - Хурлын шийдвэрийн дагуу нийт 17 (4+6+7) хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгуулахыг дэмжсэн шийдвэр 	100%

	<p>болон бусад холбогдох мэдээлэл, материалыг https://license.mn/ системд шилжүүлсэн.</p> <ul style="list-style-type: none"> - ММНБИ-ийн Динамик систем дэх тусгай зөвшөөрөл хүссэн хуулийн этгээдийн хүсэлт, бүртгэл, хяналтын үйл ажиллагааг Тусгай зөвшөөрлийн цахим систем license.mof.gov.mn-ийн модульд нийцүүлэн, ашиглалтыг хэвшиүүлсэн. <p>7. Шинээр батлагдсан Мэргэжлийн Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Дүрэм (Хараат Бус Байдлын Олон Улсын Стандартыг Багтаасан)-ийн цахим хичээлийн хөтөлбөр боловсруулж, сургалт явуулах, олон нийтэд сурталчлан таниулах:</p> <ul style="list-style-type: none"> - Мэргэжлийн Нягтлан бодогчдын Ёс зүйн Олон Улсын Дүрэм (Хараат Бус Байдлын Олон Улсын Стандартыг Багтаасан) 2018-ын монгол хэл дээр орчуулагдсан хувилбарт тулгуурласан Мэргэжлийн нягтлан бодогчийн ёс зүйн Олон улсын дүрэм цахим хичээлийг шинээр боловсруулж, Аудиторын сургалтын хөтөлбөрт тусган, судлуулж байна. - Мэргэшсэн нягтлан бодогчийн эрх сунгах хавар, намрын сургалтууд, аймгуудад оны эхний хагас жилд зохион байгуулагдсан мэргэшсэн нягтлан бодогчдын бүсийн сургалтуудад Мэргэжлийн нягтлан бодогчийн Ёс зүйн Олон Улсын дүрмийг танилцуулах хичээлийг зааж, мэргэшсэн нягтлан бодогч гишүүд болон сургалтад хамрагдсан бусад нягтлан бодогч, санхүүчдэд танилцуулсан. - Мэргэжлийн Нягтлан бодогчдын Ёс зүйн Олон улсын дүрэм 2018-ын Сангийн Сайдын дэргэдэх НББАСЗ-өөр батлагдсан монгол хэл дээрх орчуулгад үндэслэн Монгол Улсын Мэргэшсэн нягтлан бодогчдын Ёс зүйн дүрмийг шинэчлэн боловсруулж, 2023 оны 2 дугаар улиралд ММНБИ-ийн Мэргэжлийн хариуцлагын хороо болон Удирдах зөвлөлөөр төслийг хэлэлцсэн. - Мөн Мэргэшсэн нягтлан бодогчдын Ёс зүйн дүрмийн шинэчлэн боловсруулсан төслийг танилцуулах видео танилцуулгыг бэлтгэж, ММНБИ-ийн цахим сувгууд болох веб сайт, facebook хуудас, youtube суваг болон бусад олон нийтийн сүлжээгээр гишүүд, олон нийт, аудитын компаниудад танилцуулж, орон даяар нийт гишүүдээс санал авах ажлыг 2023 оны 7-9 дүгээр сард улиралд зохион байгуулсан. - Үүний үр дүнд 2023 оны 10 дугаар сарын 10-ны өдөр ММНБИ-ийн Удирдах зөвлөлийн хурлаар Мэргэшсэн нягтлан бодогчдын Ёс зүйн дүрэм шинэчлэгдэн батлагдаж, 2023 оны 10 дугаар сарын 28-ны өдөр Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгэгдэн албан ёсоор мөрдөгдөж эхлээд байна. - Мэргэшсэн нягтлан бодогчдын ёс зүйн дүрмийн шинэчлэгдэн батлагдсан хувилбарыг гишүүд болон олон нийтэд сурталчлан таниулах зорилгоор Олон Улсын Ёс зүйн өдрийг тохиолдуулан олон нийтийн цахим сувгууд болон CPA Plus сэтгүүлээр дамжуулан гишүүд, олон 	100%
--	--	------

	<p>нийтэд давтамжтайгаар хүргэсэн. Мөн 150 гаруй аудитын компаниудыг хамруулсан дэлгэрэнгүй танилцуулах сургалтыг цахимаар хийж, ММНБИ-ийн салбаруудаас Булган, Орхон, Өмнөговь аймгуудад зохион байгуулсан танхимын сургалтад нийтдээ 250 орчим санхүүч, нягтлан бодогчдыг биечлэн хамрууллаа.</p> <ul style="list-style-type: none"> - Мөн шинэчлэгдэн батлагдсан “Мэргэшсэн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм”-ийг Хараат бус байдлын стандартууд болон Нэр томъёоны тайлбарын хамт хэрэглэгчдийн бүлэгт нийцүүлэн тус тусад нь товхимол болгон 2,000 хувь хэвлүүлж, гишүүдэд хүргүүлэх ажлыг эхлүүлээд байна. 	
	<p>8. Гишүүдийн ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэх, хариуцлага тооцох үйл ажиллагааг ММНБИ-ийн Уз-ийн дэргэдэх хараат бус Мэргэжлийн Хариуцлагын Хороогоор дамжуулан хэрэгжүүлэх, өмнө нь үүссэн кейсүүдээр сургалт зохион байгуулах:</p> <ul style="list-style-type: none"> - ММНБИ-ийн Мэргэжлийн хариуцлагын хороонд гишүүдийн ёс зүйн зөрчилтэй холбоотой 4 хүсэлт ирснийг бүртгэн авч, “Мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан хянан шийдвэрлэх журам”, “Мэргэжлийн хариуцлагын хорооны ажиллах журам”-ын дагуу 3 хүсэлтийг хянан шийдвэрлэж, үлдэх 1 хүсэлтийг хянан шийдвэрлэх ажиллагаа явагдаж байна. - Мөн гишүүдийн ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэх үйл явцын талаар видео шторк, newsletter бэлтгэж, Институтийн цахим хуудас болон CPA Plus сэтгүүлэээр дамжуулан гишүүд, олон нийтэд мэдээлэх, сурталчлан таниулах ажлыг зохион байгууллаа. - Өмнө нь ММНБИ-ийн Ёс зүйн хороогоор хэлэлцэн шийдвэрлэсэн болон энэ онд үүссэн кейсүүдээр сан бүрдүүлж, Ёс зүйн дүрмийн сургалтын хичээлд ашиглахаар сургалтын материалд тусгаж байна. 	100%
2.1.4 Нягтлан бодох бүртгэл, аудитын олон улсын стандарт, түүний нэмэлт өөрчлөлтийг орчуулах холбогдох арга, аргачлалыг боловсруулах;	<p>9. Олон Улсын Чанарын Удирдлагын Стандарт 1, 2-ыг орчуулж, Сангийн сайдын дэргэдэх НББАСХ-оор батлуулах:</p> <ul style="list-style-type: none"> - АБОУС 2020-ийг бүрэн орчуулж, 2023 оны 6 дугаар сард хоёр ботиор хэвлүүлэн гаргасан. Энэ 2 ботийн 1-р ботид ЧУОУС 1, 2-ийн орчуулга орсон болно. <p>10. СТОУС 2021 оны Б Хэсэг буюу “Хэрэгжүүлэх заавар удирдамж”-ийг бүрэн орчуулж гаргах:</p> <ul style="list-style-type: none"> - СТОУС-ын 2021 оны хэвлэлийн Б хэсэг буюу “Хэрэгжүүлэх заавар, удирдамж”-ийн монгол хэл дээрх орчуулгыг англи эхийн хамт 2023 оны 7 дугаар сарын 9-ний өдөр НББАСХ-ны гишүүдэд хүргүүлж, тэднээс ирүүлсэн саналыг тусгасан хувилбарыг 2023 оны 10 дугаар сарын 26-ны өдөр бүх гишүүдэд цахимаар хүргүүлсэн. <p>11. ЖДААН-үүдэд зориулан өргөн хэрэглээтэй сэдвээр модуль боловсруулах:</p> <ul style="list-style-type: none"> - Санхүүгийн тайлангийн толилуулга, Санхүүгийн байдлын тайлан, Мөнгөн гүйлгээний тайлан, Орлогын болон 	100%
		90%
		95%

	<p>дэлгэрэнгүй орлогын тайлан, Эздийн өмчийн тайлан ба хуримтлагдсан ашгийн тайлан, Санхүүгийн тайлангийн тэмдэглэл гэсэн 6 модулийн материалыг боловсруулж дуусгасан.</p> <p>12. СТОУС-ын танилцуулга бэлтгэж олон нийтэд хүргэх:</p> <p>Тайлант хугацаанд дор дурдсан сэдвүүдээр танилцуулга бэлтгэн, олон нийтэд хүргэлээ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - "СТОУС-ыг бүрэн, үнэн зөв хэрэгжүүлэхэд анхаарах асуудал" /2 дугаар улирал/ - СТОУС-ыг баталж гаргадаг НББОУСЗ болон хэвлэл ба борлуулалтыг хариуцан ажилладаг СТОУС Сангийн тухай /3 дугаар улирал/ - СТОУС-ын 2023 оны хэвлэлийг өмнөх хэвлэлтэй харьцуулан, нэмэлт өөрчлөлтийн талаар - 2024 оны 1 сарын 1-ний өдрөөс эхлэн мөрдөгдөх Тогтвортой байдлын стандарт 1, 2-ын хураангуйлсан танилцуулгыг бүрэн орчуулж, олон нийтэд танилцуулах материал бэлтгэсэн. 	
2.1.5 Санхүүгийн зөвлөх үйлчилгээ үзүүлэгч нь Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 4.1.9. Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хуулийн 23.7-д заасан хориг арга хэмжээг хэрхэн биелүүлж байгаад хяналт тавих, хэрэгжилтийг хангуулах;	<p>13. Эрсдэлийн үнэлгээ, зайны болон газар дээрх хяналт шалгалтын үр дүн болон бусад мэдээлэл, эрсдэлийн үнэлгээ/скоринг-д үндэслэн МҮЭ-ийн эрсдэлийн зэрэглэл, газар дээрх хяналт шалгалтын төлөвлөгөөг шинэчлэн батлах:</p> <ul style="list-style-type: none"> - ММНБИ-ийн "Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагаанд зайнлас болон газар дээрх хяналт шалгалт хийх журам"-ыг 2023 оны 1 дүгээр улиралд шинээр баталсан бөгөөд түүнд нийцүүлэн 2023 онд ММНБИ-ээс холбогдох МҮЭ-ийн үйл ажиллагаанд зайнлас болон газар дээрх хяналт шалгалт хийх төлөвлөгөөг боловсруулж, батлан, хэрэгжүүлж байна. <p>14. Батлагдсан төлөвлөгөөний дагуу МҮЭ-ийн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх эрсдэлд сууринлас бодлого, журам хэрэгжүүлж байгаа эсэхэд зайны болон газар дээрх хяналт шалгалт хийж, хяналт тавих:</p> <ul style="list-style-type: none"> - ММНБИ-ийн холбогдох МҮЭ-ийн үйл ажиллагаанд зайнлас болон газар дээрх хяналт шалгалт хийх төлөвлөгөөний дагуу 2023 оны 2 дугаар улиралд МУТСТ тогтолцооны эрсдэлийг үнэлэх зайны хяналт шалгалт хийсэн. - Тус зайны хяналт шалгалтад 208 МҮЭ буюу хамрагдвал зохих МҮЭ-ийн 97% хамрагдаж, нийт 12 үндсэн чиглэлийн 104 асуулгад хариулсан. Асуултын үр дүнг ОУВС-ийн аргачлалын дагуу эрсдэлийг үнэлэх матриц болон ач холбогдолор жигнэх аргаар эрсдэлийн үнэлгээг хийсэн. 	93%
		100%

	<p>15. Эрсдэлд сууринсан хяналт шалгалтын дүн болон бусад шаардлагатай мэдээллийг МБ-ны СМА болон СЯ-нд тухай бүр хүргүүлсэн байх.</p> <ul style="list-style-type: none"> - 2023 оны 2 дугаар улиралд “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагаанд зайнаас болон газар дээрх шалгалт хийх журам”-ын дагуу МУТСТ тогтолцооны эрсдэлийг үнэлэх зайны хяналт шалгалтыг нийт 208 Мэдээлэх үүрэгтэй этгээдийг хамруулан хийсэн бөгөөд тус шалгалтын дүн болон тайланг Сангийн яам болон Монголбанкны дэргэдэх Санхүүгийн мэдээллийн албанд тухай бүр хүргүүлсэн. - Мөн Монголбанкны Санхүүгийн мэдээллийн алба, АНУ-ын Сангийн яамны Техник туслалцааны албаны зөвлөхтэй хамтран хийсэн уулзалтад ММНБИ-ийн МҮЭ-д хийсэн хяналт шалгалтын дүнг танилцуулж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал солилцсон. 	100%
2.1.6 Санхүүгийн зөвлөх үйлчилгээ үзүүлэгчийн Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хуулиар хүлээсэн үүргийг таниулах, хэрэгжүүлэх талаар сургалт, сурталчилгаа явуулж, арга зүйн удирдлага, зөвлөгөө, мэдээллээр хангах;	<p>16. Мэдээлэх Үүрэгтэй Этгээдийн үүрэг, хариуцлагын талаар мэдлэгийг дээшлүүлэх, зорилтом түвшинд хүргэх сургалт, сурталчилгааны ажлуудыг зохион байгуулах:</p> <ul style="list-style-type: none"> - ММНБИ-ийн МҮЭ-ийн “Комплаенсийн ажилтнуудад зориулсан сургалт”-ын агуулга, хөтөлбөрийг МУТСТ тогтолцооны хүрээнд эрх бүхий байгууллагаас гаргаж буй зөвлөмж заавар, мөн сургалтад хамрагдсан суралцагчдын санал хүсэлт, эрх бүхий байгууллагаас ирүүлсэн саналын дагуу шинэчлэн боловсруулсан. Ингэснээр МҮЭ-ийн “Комплаенсийн ажилтнуудад зориулсан сургалт”-ын хөтөлбөрт Үндэсний эрсдэлийн үнэлгээ болон салбарын эрсдэлийн үнэлгээ, МҮЭ-ийн эрсдэлийн удирдлага, эрсдэлд сууринсан аргачлалыг ашиглах; Харилцагчийг таньж мэдэх арга, эцсийн өмчлөгчийн талаар; Сэжигтэй гүйлгээг мэдээлэх GoAML платформыг ашиглах сэдвүүд шинээр тусгагдсан. Сургалтад МБ-ны СМА, ТТЗ, ХЗДХЯ, ММНБИ-ийн сургагч багш хичээл зааж, нийт 40 МҮЭ-ийн 48 комплаенсийн ажилтнуудыг хамруулсан. - Терроризмтой тэмцэх зөвлөлийн АНУ-ын Төрийн департментын Экспортын хяналт, хилийн аюулгүй байдал (EXBS)-ын хөтөлбөрийн санхүүжилтээр зохион байгуулсан ахисан түвшний сургалтад нийт Аудитын хуулийн этгээдүүдийг хамруулсан. - СЗХ-той хамтран зохион байгуулдаг “Даатгалын байгууллагад аудит хийх аудиторуудад зориулсан эрх олгох сургалт”, “Үнэт цаасны заах зээлд оролцогчдод аудит хийх эрх олгох сургалт” “Виртуал хөрөнгийн зах зээлд оролцогчдод аудит хийх эрх олгох сургалт”-ын хөтөлбөр болон ММНБИ-ийн Аудиторын сургалтын хөтөлбөрт Мэдээлэх үүрэгтэй этгээдийн МУТСТ үүрэг хариуцлагын талаарх хичээлийг тусгаж, мэдлэг, мэдээлэл олгох ажлыг хэрэгжүүлж байна. - ММНБИ-ийн саналаар аудитын хуулийн этгээдийг Мэдээлэх үүрэгтэй этгээдэд хамааруулан холбогдох хууль тогтоомжид тусгагдсан зохицуулалт, ойлголттой холбоотой асуудлыг шийдвэрлүүлэхээр Монголбанкны 	100%

	<p>дэргэдэх Санхүүгийн мэдээллийн албаны хамтарсан хэлэлцүүлэг зохион байгууллаа.</p> <p>17.Холбогдох хууль тогтоомжийн өөрчлөлт шинэчлэлт, FATF болон бусад эрх бүхий байгууллагаас гаргасан мэдээлэл, материалыг холбогдох мэдээлэх үүрэгтэй этгээдүүдэд шуурхай хүргэх, мэдээллээр хангах:</p> <ul style="list-style-type: none"> - ММНБИ-ийн цахим хуудасны МУТСТ холбоотой дэд цэсийг шинэчилж, эрх бүхий байгууллагаас гаргасан шинэ мэдээ, мэдээлэл, заавар зөвлөмжийг тогтол байршуулж, шинэчилж байна. - Түүнээс гадна холбогдох мэдээ, мэдээллийг Институтийн цахим хуудас, бүртгэлтэй имэйл хаяг болон олон нийтийн сүлжээний бусад сувгууд, Институтийн CPA Plus сэтгүүлээр дамжуулан тухай бүр мэдээлж, сурталчлах ажлыг хэвшүүлсэн. Тухайлбал, ФАТФ-аас гаргасан МУТСТ/YОХЗДСТ тогтолцооны дутагдалтай улсуудын жагсаалт, ФАТФ-ын 40 зөвлөмжийн техник хэрэгжилт, мөн АНУ-ын OFAC-аас гаргасан хориг арга хэмжээний жагсаалтад оруулсан өөрчлөлт зэрэг мэдээллийг нийт МҮЭ-эд цахим сувгуудаар болон CPA Plus сэтгүүлийн 2023 оны 2 болон 3 дугаарт нийтлэн хүргүүлсэн. 	
2.1.7.Аж ахуйн нэгж, байгууллагын ашиглаж байгаа нягтлан бodoх бүртгэлийн программ хангамж нь Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Улсын секторын нягтлан бodoх бүртгэлийн олон улсын стандарт болон холбогдох заавар журамд нийцсэн эсэхэд үнэлгээ хийн дүгнэлт гаргах;	<p>18.Аж ахуйн нэгж, байгууллагад зориулж шинээр хөгжүүлсэн нягтлан бodoх бүртгэлийн программд үнэлгээ хийн дүгнэлт гаргах:</p> <ul style="list-style-type: none"> - Тайлант хугацаанд Монголын Мэргэшсэн Нягтлан Бодогчдын Институтийн үйл ажиллагаанд дагаж мөрдөх Аж ахуй, нэгж байгууллагын нягтлан бodoх бүртгэлийн программ хангамжид үнэлгээ хийх, дүгнэлт гаргах журмыг баталсан. - Программ хангамжид дүгнэлт гаргах ажлын хэсгийг нягтлан бodoх бүртгэл болон программын чиглэлээр мэргэшсэн зөвлөх болон бусад шаардлагатай оролцогч талуудаар бүрдүүлэн байгуулсан. - 2023 онд нийт 7 хуулийн этгээдээс программд үнэлгээ хийлгэх хүсэлт ирүүлсэн бөгөөд 3 компанийн программд дүгнэлт гарган, 1 компанийн хүсэлтийг дахин сайжруулалт хийхээр буцаасан бөгөөд 3 компани дүгнэлт гаргуулах хугацаагаа хойшилтуулсан. - Дүгнэлт гарсан 1 компанийн холбогдох мэдээллийг 2023 оны 12 дугаар сарын 4-ний өдөр Сангийн яаманд албан бичгээр хүргүүлсэн. <p>19.НББ-ийн программ зохиогчдод сургалт зохион байгуулах, мэдээлэл, зөвлөгөө өгч, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавих.</p> <ul style="list-style-type: none"> - 2023 оны 6 дугаар сарын 14-ний өдөр “НББ-ийн программ хангамж”-ийн эрх сунгах, шинээр олгохтой асуудлаар уулзалт зохион байгуулсан бөгөөд уулзалтад Институтийн эрх бүхий албан тушаалтнууд болон тухайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй 17 компанийн төлөөлөл оролцсон. 	100%
		90%

	<p>- Уулзалтад Институтийн Ерөнхийлөгч Б.Түвшин, Гүйцэтгэх захирал Б.Оюунбаатар нар мэргэжлийн байгууллагын үйл ажиллагааны талаар танилцуулга хийлээ. Мөн нягтлан бодох бүртгэлийн программ хангамжид дүгнэлт гаргах ажлын хэсгээс программ хангамжийг сунгах болон шинээр олгох, хүсэлт хэрхэн хүлээн авах талаар мэдээлэл хийсэн.</p>	
--	--	--

2023 оны жилийн эцсийн байдлаар гэрээний үүргийн биелэлт **97.6 хувь** гэж хоёр тал харилцан тохиролцов.

ГЭРЭЭ ДҮГНЭСЭН АКТ ҮЙЛДСЭН:

САНГИЙН ЯАМЫГ ТӨЛӨӨЛЖ:



САНГИЙН САЙД
Б.ЖАВХЛАН

САНГИЙН ЯАМНЫ НЯГТЛАН БОДОХ
БҮРТГЭЛИЙН БОДЛОГЫН ГАЗРЫН
ДАРГА Б.БОЛОРМАА

Болормаа

МОНГОЛЫН МЭРГЭШСЭН НЯГТЛАН
БОДОГЧДЫН ИНСТИТУТИЙГ
ТӨЛӨӨЛЖ:



ИНСТИТУТИЙН ЕРӨНХИЙЛӨГЧ
Б.ТҮВШИН

МОНГОЛЫН МЭРГЭШСЭН НЯГТЛАН
БОДОГЧДЫН ИНСТИТУТИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Б.ОЮУНБААТАР

Б.Түвшин